



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 94

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

“Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлыг зохицуулах зөвлөл”-ийн 2005 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын 2,6-г үндэслэн ТУШААХ нь:

1. Бадралт овогтой Анарыг АНУ-ын Омаха хотын Небраскагийн Их сургуульд, Бямбасүрэн овогтой Тамирыг ХБНГУ-ын Фрайберг хотын Уул уурхайн академийн магистрантурт, Баяртсайхан овогтой Хуланг АНУ-ын Калифорнийн Их сургуулийн магистрантурт тус тус 2 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Австрали улсын Гриффит их сургуулийн магистрантурт суралцаж буй Цэрэнжав овогтой Уранбилэг, Бүүвээбаатар овогтой Булганмаа нарын суралцах хугацааг тус тус хагас жилээр сунгасугай.

3. Казахстаны Алма-Аты хотын Халдвар нян, халдварт өвчин судлалын хүрээлэнгийн докторантурт суралцаж буй Бэгз овогтой Сангидоржийн хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

4. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.



САЙД

П.ЦАГААН

3735136